



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/126

Эрдэнэт

Тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэтийн Од спорт клубын ирүүлсэн хүсэлтийн дагуу Архангай аймагт 2017 оны 03 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд болох Гар бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгийг төлөөлөн оролцох тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ